

**ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН БЯХАРЖАЛБУУГИЙН АДЪЯАГИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
1	2	3					
НЭГ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Арга хэмжээ 2.13 Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн комисст орж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100%	✓ Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/58 дугаар тушаалаар Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын Б блок байрны 1 давхрын 40 мкв "Сүлжээ дэлгүүр"-ийн зориулалттай талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажилласан.	01.01 12.30	100
2	Арга хэмжээ 2.19 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн ажилд захиалагчийн хяналт тавих, захиалагчийн хяналт тавьсан төсөл, арга хэмжээний 5%-ийн барьцаа хөрөнгийг чөлөөлөх	Санхүүжилтийн дүн, сая төгрөг	-	-	Нийслэлийн өмчид шинээр бий болсон хөрөнгийг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан. Үүнд: 1. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" А/189 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газарт "Төрийн байгууллагуудын цахим тоног,	01.01 12.30	100

					төхөөрөмж" хүлээлцүүлж, холбогдох санал, дүгнэлтийг өгч ажилласан. Гэрээний дүн – 88,998,000 төгрөг 2. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/1338 дугаар захирамж, НХААГ/20240102676, дугаартай ажлын гэрээний дагуу "Эмнэлгийн тоног төхөөрөмж", НХААГ/20240102677 дугаартай гэрээний дагуу "Эмнэлгийн хэрэгсэл"-ийг ашиглагч байгууллага болох Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хан-Уул дүүргийн Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгад хүлээлцүүлж, холбогдох санал, дүгнэлтийг өгч ажиллав. Гэрээний дүн – 100,996,000 төгрөг - 23,788,000 төгрөг 3. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/107 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/186 дугаар захирамж, НХААГ/20250101548-2 дугаартай гэрээний дагуу Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн хүчилтөрөгчийн үйлдвэр байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж суурилуулах ажил хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.	
--	--	--	--	--	--	--

					Гэрээний дүн – 553,221,900 төгрөг 4. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2025 оны 27-ний өдрийн А/56 дугаар тушаалаар Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/317 дугаар захирамжаар Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй тус дүүргийн 1-11, 14-21 дүгээр хороодод камер суурилуулах ажлуудыг ашиглалтад хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан. 5. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2025 оны А/95 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Эрх шилжүүлэх тухай” А/20 дугаар захирамжийн дагуу Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл тоног төхөөрөмж Багц-5 дагалдах хэрэгсэл тоног төхөөрөмж хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан. 6. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2025 оны А/99 дүгээр тушаалаар Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Эрх шилжүүлэх тухай” А/445 дугаар захирамжийн дагуу Соёлын төв өргөөний тоног төхөөрөмж хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025.10.10-ны өдрийн “Хотын аж ахуйн ажлыг байнгын ашиглалтад хүлээж авах комисс байгуулах тухай” А/149 дүгээр тушаал байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдон дараах ажлуудыг хүлээн авсан.	
--	--	--	--	--	---	--

					7. СБД-ийн 17-р хороо, Япон иргэний дурсгалын цогцолборт явган замын гүүрэн байгууламж болон гэрэлтүүлгийн ажил хүлээн авах комисст ажилласан. 8. БЗД-ийн 16-р хороо, 24-р байрны урд талбайн бичил цэцэрлэгт хүрээлэн 9. БЗД-ийн 6-р хорооны нутаг дэвсгэрт бичил цэцэрлэгт хүрээлэн 10. БЗД-ийн 34-р хорооны нутаг дэвсгэрт бичил цэцэрлэгт хүрээлэн 11. БЗД-ийн 27-р хорооны нутаг дэвсгэрт бичил цэцэрлэгт хүрээлэн. 12. СХД-ийн хогийн цэгт хийсэн тохижилтын ажил <u>Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэх тухай</u> 1. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 25/58 дугаар тогтоолоор нийслэлийн өмчид иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас үнэ төлбөргүй шижлүүлж буй нийт 2,442,061,654 төгрөгийн үнэ бүхий орон сууцны инженерийн шугам сүлжээг нийслэлийн өмчид бүртгэхээр шийдвэрлэсэн.		
3	Арга хэмжээ 2.29 Холбогдох хууль тогтоомж, журмын төсөлд санал өгөх	Саналын тоо Хэрэгжилтийн хувь	3	100%	✓ Орон сууцны болон орон сууцны бус зориулалттай байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хууль ✓ Худалдан авах ажиллагааны тухай хуулийн төслүүдтэй танилцсан.	01.01 12.30	100
4	Арга хэмжээ 2.31 Нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа аливаа хуулийн этгээдийн өмчийн эзэмшилт, өөрчлөлт, захиран	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Нийслэлийн өмчит хуулийн этгээдүүдийн эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа барилга байгууламжийн ашиглалт, өөчлөлт, захиран зарцуулалтад байгууллагын чиг үүргийн хүрээнд хяналт, шалгалтын	01.01 12.30	

	зарцуулалт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллах			төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд: 1. Ашиглалтгүй болон илүүдэлтэй байр талбай тогтоох : Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/798 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь тус тушаалын хүрээнд нийслэлийн төвийн 6 дүүрэгт нийт 112 барилга байгууламжийг сонгон 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрүүдэд газар дээр нь очиж үзэн танилцаад, холбогдох заавар зөвлөмжийг өгч ажиллаа. Барилга байгууламжид: ✓ Баянзүрх дүүрэг: 16 барилга байгууламж ✓ Сүхбаатар дүүрэг: 21 барилга байгууламж ✓ Чингэлтэй дүүрэг: 19 барилга байгууламжууд хамрагдсан болно. Дээрх барилга байгууламжаас ашиглалтгүй хоосон байсан Сүхбаатар дүүрэгт – 4, Чингэлтэй – 3 байсан. Сүхбаатар дүүрэг дэх сул байр талбай: - Төр захиргааны нэгдсэн барилгын 10 дугаар давхарт байрлах цайны газрын зориулалттай 168м2 талбай; - Эрүүл мэндийн Салбар амбулатори 2-ын төвийн 2 давхар барилга; - Сувиллын сэргээн засах төвийн 4 давхар барилга; - Хүрээ амаржих газрын хуучин 4 давхар барилга. Чингэлтэй дүүрэг дэх сул байр талбай:	100
--	--	--	--	---	------------

					- 16 дугаар хороонд байрлах иргэний танхим; - Эрх зүйн туслалцааны төвийн 2 давхар барилга; - Хайрхан хөгжлийн төвийн 4, 5 давхруудад 3 өрөө сул байв. Түрээстэй холбоотой асуудлаар: НӨХГ-тай гурвалсан гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж холбогдох төлбөрийг өөрсдөө авч байсан зөрчил илэрсэн. Үүнд: Баянзүрх дүүрэгт: ➤ Соёлын ордон - 1-р давхарт кофе шоп гэрээгүй. - Булангийн жижиг дэлгүүр гэрээгүй. - Хурдангийн төхөөрөмж гэрээгүй. - Гэрэгэ киоск машин гэрээгүй. ➤ Эрүүл мэндийн төв - Ундааны автомат машин гэрээгүй. - Хурдан лавлагааны машин гэрээгүй. ➤ Дарь-Эх нэгдсэн эмнэлгийн барилга - Хурдан лавлагааны машин болон 12м² талбайд өрөө ашиглан улсын бүртгэлийн лавлагааг гаргадаг түрээсийн гэрээгүй. ➤ 27-р хороо, Иргэдэд үйлчлэх барилга - Лавлагааны машин 2 гэрээгүй Сүхбаатар дүүрэгт: ➤ ЖДҮДТ-ийн барилга ➤ Төрийн захиргааны нэгдсэн байр - Худалдаа хөгжлийн банкны бэлэн мөнгөний машин гэрээгүй. - Хур-дан-2ш автомат машин гэрээгүй - Киоск-1ш автомат машин гэрээгүй	100
--	--	--	--	--	--	-----

					➤ СБД-ийн төв поликлиникийн барилга - Хур-дан лавлагааны машин гэрээгүй - Автомат ундааны машин гэрээгүй. ➤ Улаанбаатар хотын нийтийн төв номын сан- ХУД дэх салбар номын сан - АНУ-ын Соёл мэдээллийн төв гэрээгүй. - Монгол судлалын төв гэрээгүй. Улаанбаатар хөгжлийн корпорацитэй түрээсийн гэрээтэй. ➤ Өргөө амаржих газар- Г блок - 1-р давхарт ус ундааны автомат машин гэрээгүй. Чингэлтэй дүүрэгт: ➤ Засаг даргын Тамгын газрын Нэг цонхны үйлчилгээний өргөтгөл - 2 лавлагааны машин гэрээгүй; ➤ Хайрхан хөгжлийн төвийн барилга 2 ОНӨТҮГ - Батбайгаль бейкери ХХК гэрээгүй. ➤ Хайрхан хөгжлийн төвийн барилга 1 ОНӨТҮГ - Гэрэгэ лавлагааны машин гэрээгүй. - Юнител антен гэрээгүй - Батбайгаль бейкери ХХК гэрээгүй. - Сүүж уулын оргил цайны газар гэрээгүй. 2. Эрүүл мэндийн байгууллагууд байр талбай : Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/40 дүгээр тушаалын дагуу Нийслэлийн өмчийг	100
--	--	--	--	--	---	-----

					эзэмшүүлэх гэрээтэй эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламжийн эзэмшилт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг газар дээр нь очиж танилцан, холбогдох зөвлөмжийг өгч ажиллалаа. Баянзүрх дүүргийн хэмжээнд – 46 байгууллагын 52 барилга байгууламж: - Нэгдсэн эмнэлэг - 0 - Дүүргийн эрүүл мэндийн төв – 3, салбар - 7 - Өрийн эрүүл мэндийн төв - 40 - Нийслэлийн эрүүл мэндийн байгууллага - 3 Сүхбаатар дүүргийн хэмжээнд: - 21 байгууллагын 37 барилга байгууламж - Нэгдсэн эмнэлэг – 1 - Дүүргийн эрүүл мэндийн төв – 1, салбар - 4 - Өрийн эрүүл мэндийн төв - 16 - Нийслэлийн эрүүл мэндийн байгууллага - 3 Чингэлтэй дүүргийн хэмжээнд: 19 байгууллагын 21 барилга байгууламж - Нэгдсэн эмнэлэг - 1 - Дүүргийн эрүүл мэндийн төв – 1, салбар - 4 - Өрийн эрүүл мэндийн төв - 17 3. Нийслэлийн өмчит ерөнхий боловсролын сургуулиуд болон ЗДТГ, ИТХ-ын барилга байгууламжид:	100
--	--	--	--	--	---	-----

					Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/62 удирдамжын дагуу Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэдийн хурал, Тамгын газар, Боловсролын байгууллагууд газар дээр нь очиж үзэн, хяналт шалгалтыг хийж, зөрчлийг илрүүлэн, зөвлөмж зөвлөгөөг өгч ажиллаж байна. ➤ Баянзүрх дүүрэг – 38 байгууллага; ➤ Чингэлтэй дүүрэг – 22 байгууллага, ➤ Сүхбаатар дүүрэг – 23 байгууллагуудаар тус тус явж, холбогдох тэмдэглэлийг хөтөлж, баримтжуулан ажиллаж байна. 4. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, хөрөнгөд хийсэн хяналт шалгалт: <u>1. Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ</u> Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/244 дүгээр тушаалаар “Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-ын санхүү болон хөрөнгийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, зарцуулалтад хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан 2025.08.05-2025.08.06-ны өдрүүдэд тус газрын байранд байрлан, холбогдох бичиг баримтад нь тулгуурлан ажиллалаа. Үүнд: - 2025 оны хагас жилийн тайланд 2024 оны санхүүгийн тайланд тусгасан 2,538,526,973 төгрөгийн орлогыг <u>дахин</u> орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан; - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.2,	
--	--	--	--	--	---	--

					10.3, 31.2 дэх заалт, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолийн шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг зөрчин шууд худалдан авалт зохион байгуулсан; - Худалдах, худалдан авах гэрээний дагуу хүлээж авсан хөрөнгийг цаг тухай бүр данс бүртгэлд тусгаж, коджуулаагүй, карт нээж, эзэнжүүлээгүй; - 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд тоног төхөөрөмж, компьютер хэрэгсэл, тавилга эд хогшлын дансанд орлого авахдаа холбогдох тушаал шийдвэрийг гаргаагүй; - Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/274 дүгээр захирамжаар 10ш автобусыг Нийтийн тээврийн бодлогын газрын балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн боловч шийдвэрийн хэрэгжилтийг хангаагүй, 2025 оны хийж хагас жилийн тайланд тусгаж, хасалт хийгээгүй; - Санхүүгийн тайланд бүртгэсэн 15-04УЕХ, 15-05УЕХ, 15-77УЕХ, 15-85УЕХ улсын дугаартай тээврийн хэрэгслүүд НЗД-ын 2024 оны А/1036 захирамжийн хавсралтаас зөрүүтэй; - Автобусанд байрлах бэлэн мөнгөний хайрцагаар орж ирсэн орлогыг харуул хамгаалалт муутай, оффисын байрны нэг давхарт үүдний хэсгийн вакум ханаар тусгаарласан өрөөнд 1 ажилтан орлогыг тоолж, шалгах, бүртгэх ажлын хэсгийг бүрэн бүрэлдэхүүнгүй, хяналтгүй;	
--	--	--	--	--	--	--

					- 2024, 2025 оны эдийн засгийн үндсэн зорилтот түвшнийг батлуулахдаа хүүгийн орлого тусгаагүй; /2024 онд 8,6 сая төгрөг, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 6,8 сая төгрөгийн хүүгийн орлого олсон байна./ - Нийслэлийн Засаг даргатай байгуулах "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г шинээр томилогдсон захирал Д.Жавхлан байгуулаагүй; - 2025 оны эдийн засгийн зорилтот түвшний талаарх танилцуулга, эдийн засгийн тооцоолол мөн түүнийг хэлэлцүүлсэн Удирдах зөвлөлийн шийдвэрийн хамт ирүүлээгүй. Дээрх зөрчил дутагдлийг арилгаж ажиллах талаар НӨХГ-ын 2025.08.28-ны өдрийн 1/1461 тоот албан бичгээр тус газарт хүргүүлсэн. 2. Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/261 дүгээр тушаалаар "Зорчигч тээвэр нэг" ОНӨААТҮГ-ын санхүү болон хөрөнгийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, зарцуулалтад хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан 2025.09.04-2025.09.17-ны өдрүүдэд тус газрын байранд байрлан, холбогдох бичиг баримтад нь тулгуурлан ажиллалаа. - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.2, 10.3, 31.2 дэх заалт, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтооллын шууд худалдан	
--	--	--	--	--	---	--

					авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг зөрчин шууд худалдан авалт зохион байгуулсан; - Нийслэлийн Засаг даргатай байгуулах "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г шинээр томилогдсон захирал Б.Хуягбаатар байгуулаагүй; - 2025 оны Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилт батлуулахдаа төлөвлөлтийг бодит бус хийсэн - 2024 оны Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын саналыг "Зорчигч тээвэр нэг" ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 24/04 дүгээр тогтоолоор батлан Засаг даргын захирамж гаргуулаагүй, 2025 оны 02 дүгээр сарын 21-ний өдрийн "Зорчигч тээвэр нэг" ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн 04 дүгээр тогтоолоор Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулан батлуулсан Засаг даргын захирамж гаргуулаагүй - Хөдөлгөөний удирдах төвийн 1 давхарт 35мк2 буфет ажиллаж байсан манай газар болон тухайн газар ямар нэгэн түрээсийн төлбөр төлдөггүй, - Хөдөлгөөний удирдах төвийн 2 давхарт 35мк талбай бүхий цайны газрыг Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо 2-4 40 мянгатын гудамж, Хөнгөн хүнсний үйлдвэрийн 1/30 байр, 7 тоотод оршин суух Пүрэвийн Шинэхүү /РД:ЧИ66042368/-нь тус газартай шууд гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байсан.		
--	--	--	--	--	--	--	--

					- “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-аас хүлээн авсан 128 тээврийн хэрэгсэл болон бусад эргэлтийн бус хөрөнгийг холбогдох тушаал шийдвэрээр данс бүртгэлд тусгаагүй, санхүүгийн тайлан баланст шууд бүртгэсэн; - “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-тай барилга байгууламж болон газар эзэмших эрх хүлээлцсэн баримт мэдээллийг гаргаж өгөөгүй. - Тус газар нь нийт 2,265,149.88 мянган төгрөгийн хөрөнгийн хөдөлгөөн хийхдээ 7 тээврийн хэрэгсэл болон 98,506.55 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох шийдвэрээр бүртгэлд тусгаж авсан бөгөөд 15,310 мянган төгрөгийн хөрөнгийг 2025 онд захирлын тушаалаар бүртгэсэн нь НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журмын 3.2.4 дэх заалтыг зөрчсөн байна. - НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журмын 3.2.2 дахь заалтын дагуу тээврийн хэрэгслийг бүртгээгүй, мөн журмын 7.3 дахь жагсаалтыг хэрэгжүүлж хөрөнгө бүртгэсэн захирлын тушаалыг ирүүлээгүй байна.	
	ХОЁР. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					

5	Арга хэмжээ 3.2 Хяналт шалгалтын байгууллага, дээд байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах	Ирүүлсэн зөвлөмжийн тоо, хэрэгжилтийн хувь	-	-	1. Нийслэлийн өмчийн балансад бүртгэлтэй Соёлын Төв өргөөний Г блокд байрлах нийслэлийн харьяа 6 байгууллага, 24 иргэн, аж ахуй нэгжийн байрлан үйл ажиллагаа явуулж буй 150 гаруй өрөө тасалгааг баталгаажуулсан. Нийт 30 иргэн аж ахуй нэгжид байр талбай чөлөөлөх тухай мэдэгдэл хуудсыг нэгжийн дарга, Г.Тэмүүжин, мэргэжилтэн П.Түвшинжаргалтай хамт хүргүүлж ажилласан. Сул байр талбай ашиглалтыг мэдээллийг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр танилцуулсан болно. 2. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/12 дугаар захирамжаар Улсын төсвийн хөрөнгөөр Улаанбаатар хотын нийтийн тээврийн шинэчлэлтийн ажлын хүрээнд худалдан авсан 400 автобуснаас Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч "Эрдэм Транс" ХХК-тай хэлцлийн дагуу шилжүүлсэн 30 автобусны өр төлбөр болон гэрээний торгуулийн үлдэгдэл төлбөр болох нийт 2,143,165,833 (хоёр тэрбум нэг зуун дөчин гурван сая зуун жаран таван мянга найман зуун гучин гурав) төгрөгт, компанийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлэн өр төлбөрөөс барагдуулж тооцох үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг 2025 оны 02 дугаар сарын 06, 02 дугаар сарын 10-ны өдрүүдэд хуралдаж, дээрх захирамжийн хүрээнд дараах ажлыг зохион байгуулж ажиллав. Үүнд: 1. "Эрдэм транс" ХХК-ийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг үнэлүүлэх нээлттэй сонгон шалгаруулалтыг 2025.02.03-2025.02.10-ны өдөр хүртэл Нийслэлийн Өмчийн	01.01 12.30	100
---	---	--	---	---	--	----------------	-----

					харилцааны газар болон Нийслэлийн Тээврийн бодлогын газрын цахим хуудсанд зарласан. 2. Дээрх сонгон шалгаруулалтын хүрээнд ирүүлсэн материалуудаас 2025.02.10-ны өдөр ажлын хэсгийн бүрэлдэхүүн "Ган гурван од" ХХК-ийг сонгон шалгаруулсан. 3. Сонгон шалгаруулсан компанитай гэрээ байгуулах эсэх талаар чиглэл өгөхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 2/312 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. 4. НЗДТГ-аас өгсөн чиглэлийн дагуу Нийслэлийн Тээврийн бодлогын газар "Эрдэм транс" ХХК-ийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хийлгэх тухай гэрээг "Гурван ган од" ХХК-тай байгуулав. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/12 дугаар захирамжаар өгсөн үүрэг даалгавар дээрх асуудлын хүрээнд хийгдэж дуусгавар болсон болно.		
6	Арга хэмжээ 3.6 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар мод тарих	Модны тоо, Өртөг, сая төг	25	100%	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд байгууллагын хэмжээнд Налайх дүүрэг дэх цэцэрлэгт хүрээлэнд 2025.05.03, 2025.10.14-ний өдрүүдэд мод тарисан.	01.01 12.30	100
7	Арга хэмжээ 6.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Холбогдох мэдээ, мэдээлэл, танилцуугыг цаг тухай бүр гаргаж өгч ажилласан болно.	01.01 12.30	100

8	Арга хэмжээ 6.3 Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах, хяналт тавих	Үүрэг даалгаврын тоо, гүйцэтгэлийн хувь	65 100%	100%	1. Нийслэлийн Өмч хувьчлах комисс энэ сарын 15-ны өдөр хуралдаж, НЗД-ын дэргэдэх "Уламжлалт анагаах ухааны Элэг судлалын клиник төв"-ийг менежментийн гэрээгээр ажиллуулах 73 дугаар тогтоолыг хүчингүй болгосон. Энэ хүрээнд тус төвийн "Богд уул" сувиллыг хууль бусаар ашиглаж байсныг таслан зогсоож, нийслэл өмчлөлдөө буцаан авах ажиллагаа хийгдлээ. Үүнтэй холбоотой дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан. Үүнд: - "Уламжлалт анагаах ухааны Элэг судлалын клиник төв"-ийн харьяа "Богд уул" сувиллын хөрөнгийг тоолох ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 13:00-17:00 цагийн хооронд Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн баг бүрэлдэхүүнтэй хамтран нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Тэмүүжин, хяналт шалгалтын мэргэжилтэн О.Уранчимэг, Ш.Дарьсүрэн, Б.Адъяа, Г.Уранцэцэг, П.Түвшинжаргал, Захиргаа удирдлагын хэлтсийн ажилтан Б.Батбаяр нар газар дээр нь очиж, хөрөнгийг тоолж, хүлээлцэх ажилд хяналт тавьсан. - Энэ хүрээнд нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Уламжлалт анагаах ухааны Элэг судлалын клиник төв"-д их засвар хийгдэж байна. Тус клиник төвийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх	01.01 12.30	100
---	--	---	------------	------	---	----------------	-----

					зорилгоор тусламж, үйлчилгээг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн засварын ажил дуусах хүртэл Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлгийн харьяа Баянгол дүүргийн 20 дугаар хороонд байрлах салбар амбулаторид түр хугацаагаар шилжүүлэн ажиллуулахаар шийдвэрлэсэн. “Уламжлалт анагаах ухааны Элэг судлалын клиник төв”-ийн хөрөнгийг түр нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 11:00-17:00 цагийн хооронд нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Тэмүүжин, хяналт шалгалтын мэргэжилтэн О.Уранчимэг, Ш.Дарьсүрэн, Б.Адъяа, Г.Уранцэцэг нар газар дээр нь очиж хөрөнгийг тоолж, хүлээлцэх ажилд хяналт тавьсан. Эмнэлгийн 2 дугаар давхарт байрлах захиргааны хэлтсийн 7 өрөө, дотор байрлах эд хогшлыг тоолох ажиллагаанд хяналт тавьж, битүүмжлэн лацадсан. 1. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/85 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан “Улаанбаатар радио” ХХК-ын эзэмшиж байгаа барилга, газрыг хүлээлцлээ. Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороонд байрлах Баруунсэлбэ үйлчилгээний төвийн Ж блокийн “Улаанбаатар радио” ХХК-ын эзэмшиж байсан барилга, газрыг хүлээн авах ажлын хэсэгт Өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Тэмүүжин,	100
--	--	--	--	--	--	-----

					мэргэжилтэн П.Түвшинжаргал, Ш.Дарьсүрэн, О.Уранчимэг, Б.Адъяа, Г.Уранцэцэг, Захиргаа, удирдлагын хэлтсийн ажилтан Б.Батбаяр нар Баруунсэлбэ үйлчилгээний төвийн Ж блокийн барилгын гадна болон дотор талын өрөө, тасалгаа, цахилгааны монтажны хэсгийг газар дээр нь очин хөрөнгийг тоолж, нүд үзэн хүлээлцсэн. Барилга дотор үйл ажиллагаа явуулж байсан зургийн студи, шөнийн клуб, радио, дуу бичлэгийн студи зэрэг газрууд байр талбайг чөлөөлсөн байсан.		100
9	Арга хэмжээ 7.3 Албан хаагчийн албан үүргээ мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулсан сургалт, семинар, олон нийтийн ажилд оролцох	Арга хэмжээний тоо, гүйцэтгэлийн хувь	5 сургалт 100%	2 сургалт 100%	Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх ажлын хүрээнд: - МУИС-ын Хууль зүйн сургуульд суралцаж байна. - Нийслэлийн өмчийн мэдээллийн сангийн шинэчилсэн программ хангамжийн 3 удаагийн сургалт; - Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсээс зохион байгуулсан уулзалт, семинарын ажилд оролцсон. - Онцгой байдлын албан хаагчдын сургалтад хамрагдсан. - Олон нийтийн хог цэвэрлэгээний ажилд оролцсон. - Нийслэлийн Засаг даргын захирамжаар Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны айл өрхийн яндан тоолох ажилд оролцсон. Үүнд байгууллагын албан хаагч Дарьсүрэн, Будханд, Төмөр нартай хамтран 2025.01.18, 19-ний өдрүүдэд нийт цахим болон цаасан бүртгэлээр 144 айлын судалгааг гараж нэгтгүүлсэн	01.01 12.30	100

					байна. Холбогдох тайлан Захиргаа удирдлагын хэлтэс хүргүүлсэн.		
10	Арга хэмжээ 7.5 Хэлтсийн болон албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, биелэлтийг хугацаанд нь тайлагнах	Гүйцэтгэлийн хувь	100%	100%	2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланг гарган өгсөн.	01.01 12.30	100
ГУРАВ. "ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
11	Арга хэмжээ 9.1 Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж, монгол бичгийн ур чадвараа дээшлүүлэн, албан хэргийг хос бичгээр хөтлөн, албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх	Албан бичиг, өргөдөл гомдлын тоо, хэрэгжилтийн хувь	Албан бичиг —, 100% Өргөдөл —, 100%	100%	Тайлант хугацаанд нийт 8 албан бичиг хуулийн хугацаанд судлан шийдвэрлэсэн, 1 өргөдөл ирүүлснийг судлан холбогдох хариуг хүргүүлж ажилласан байна.	01.01 12.30	100
12	Арга хэмжээ 9.2 Архивын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын архивын сан хөмрөгийг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	-	Тайлант хугацаанд үүссэн 7 архивын нэгж болгон, архивын ажилтанд хүлээлгэн өгсөн.	01.01 12.30	100
ДӨРӨВ. НЭМЭЛТ АЖИЛ							
13	Арга хэмжээ 4.1 Удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу ажиллах	Үүрэг даалгаврын тоо	2	2	НӨХГ-ын даргын 2025.10.10-ны өдрийн А/439 дүгээр тушаалаар байгуулагдсан "Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийн санал боловсруулах" чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, байгууллагын чиг үүрэгт холбогдуулан, тусгах саналыг орж, холбогдох саналыг өгч ажиллав.	01.01 12.30	100

14					НӨХГ-ын даргын 2025.08.29-ний өдрийн А/260 дугаар тушаалаар "Нийслэлийн стратеги төлөвлөгөөг үндэслэн Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулах" ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, холбогдох саналаа өгч ажиллав.	01.01 12.30	100
----	--	--	--	--	---	----------------	-----

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх ажил	Хүрсэн түвшин		
1	2	3	4	5		
1	Үйл ажиллагаатай холбоотой шинэчлэгдсэн хууль, дүрэм, журам болон бусад холбогдолтой эрх зүйн актуудыг судалж мэдлэг чадвараа дээшлүүлнэ.	Хариуцсан ажил үүргийн дагуу холбогдох эрх зүйн актуудыг судалсан байна.	Хариуцсан ажил үүргийн дагуу холбогдох эрх зүйн актуудыг судалсан байна.	- Ажил үүргийн хуваарьтай холбоотой хууль, дүрэм, журмыг цаг тухай бүр уншиж судалж, мэдлэг чадвараа дээшлүүлж байна. - МУИС-ын Хууль зүйн сургуульд суралцаж байна.	01.01 12.30	100
2	Байгууллага болон бусад газраас зохион байгуулсан сургалт, семинар болон бусад олон нийтийн ажилд оролцох	Сургалт болон олон нийтийн ажилд хамрагдсан байна.	Байгууллага болон бусад газраас зохион байгуулсан	- Нийслэлийн өмчийн мэдээллийн сангийн шинэчилсэн программ хангамжийн 3 удаагийн сургалт; - Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсээс зохион байгуулсан уулзалт, семинарын ажилд оролцсон. - Нийслэлийн Засаг даргын захирамжаар Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны айл өрхийн яндан тоолох ажилд оролцсон. Үүнд байгууллагын албан хаагч Дарьсүрэн, Будханд, Төмөр нартай хамтран 2025.01.18, 19-ний өдрүүдэд нийт цахим болон цаасан бүртгэлээр 144 айлын судалгааг гараж	01.01 12.30	100

				нэгтгүүлсэн байна. Холбогдох тайлан Захиргаа удирдлагын хэлтэс хүргүүлсэн. - Онцгой байдлын албан хаагчдын сургалтад хамрагдсан. - Олон нийтийн хог цэвэрлэгээний ажилд оролцсон.		
--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Орхон нэрлэлт
(Албан тушаал)

Б.АДЪЯА (Б.АДЪЯА)
(Нэр, гарын үсэг)

2025. 02. 04
(Огноо)



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Хөвсгөл лэйк сити төвөр-8/1, Багагойруу 1,
8 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14200
Утас/Факс: (976-11) 32 02 48
Цахим хуудас: www.iltch.ub.gov.mn

2025.08.18	№	1/1423
танай	2025.08.12	-ны № 01/3252
		-т

「**НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН**」
ГАЗАР ОНӨААТҮГТ

Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн
хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа Эмнэлэг,
сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт,
их засварын ажил (Улаанбаатар хот,
Сонгинохайрхан дүүрэг), техник хэрэгсэл худалдан
авч дүүргийн эрүүл мэндийн төвд “Хүчилтөрөгчийн
үйлдвэр” шаардлагатай тоног төхөөрөмж
суурилуулах” Багц-2 хүлээх авах ажлын хэсэгт тус
газрын Өмчийн хяналт шалгалтын хэлтсийн
мэргэжилтэн Б.Адъяаг томилж байна.



Нийслэлийн өмчийн харилцааны газар
Захиргаа
Дарга
Володя Оюумаа
2025.08.18 11:48